



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2025/041/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061 Цахим хаяг:
boldbaatarkhu@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545 Цахим
хаяг:tsetsegsurena@audit.gov.mn

Аудитор: Н.Батжаргал
Утас:70432545 Цахим хаяг: batjargaln@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	8
3.1 Төлбөрийн акт	8
3.2 ЗӨВЛӨМЖ	9
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	26

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2025.02.21 № 2/52

танай _____-ны № _____-т

ХОВД СУМЫН
ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Б.ШОЛПАНХАН ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ховд сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 41 дүгээр зүйлийн 41.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.3 дахь заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Сүү хөтөлбөрийн зарцуулаагүй үлдэгдлийг төсөвт төвлөрүүлээгүй 1,305.4 мянган төгрөг,
- 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан гарахын өмнө хөрөнгийн тооллогыг хийгээгүй,
- Тогтмол зардлын санхүүжилтээс ус цэвэршүүлэх тоног төхөөрөмж худалдан авсан 945.0 мянган төгрөг,
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлыг бүртгэлд тусгаагүй 5,800.0 мянган төгрөг,
- Авлага болон өр төлбөрийг нэмээдүүлсэн зөрчлүүд тус тус байна

Асуудлыг онцолсон хэсэг

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд цэвэр, бохир усны шугамд холбогдон ашиглаж байгаа бөгөөд ажлыг бүрэн дуусгаагүй тул хүлээн авч хөрөнгөд бүртгээгүй байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Боловсрол шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын хамтарсан 2024 оны А/85, А/34 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан багш, ажилтны орон тооны жишиг нормативын дагуу тус цэцэрлэгт Эмч ажиллаж байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>62,751,455.34</u>	<u>135,522,532.45</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	40,898,563.34	117,944,510.45
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	40,898,563.34	117,944,510.45
3121	Төгрөг	40,898,563.34	117,944,510.45
31211	Төрийн сангийн харилцах	40,898,563.34	117,944,510.45
33	АВЛАГА	-	560,000.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	560,000.00
34	УРЬДЧИЛГАА	-	300,000.00
3471	Урьдчилгаа тооцоо	-	300,000.00
34713	Цалингийн урьдчилгаа	-	300,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	21,852,892.00	16,718,022.00
354	Хангамжийн материал	21,852,892.00	16,718,022.00
35420	Аж ахуйн материал	1,543,100.00	2,354,800.00
35460	Хүнсний материал	11,773,582.00	5,849,512.00
35470	Бусад хангамжийн материал	8,513,710.00	8,513,710.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>213,735,907.60</u>	<u>237,272,431.54</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	213,735,907.60	237,272,431.54
392	Биет хөрөнгө	205,782,107.60	229,318,631.54
39201	Барилга, байгууламж, орон сууц	170,272,480.00	170,272,480.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(14,189,373.60)	(17,027,248.32)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	30,519,656.00	53,077,086.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(19,415,123.80)	(24,605,122.20)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	27,698,182.82	39,592,682.82
39208	Хуримтлагдсан элэгдэл	(22,110,571.14)	(23,331,437.40)
39214	Бусад үндсэн хөрөнгө	38,268,990.00	38,268,990.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(5,745,961.68)	(7,412,628.36)
39217	Ном	483,829.00	483,829.00
393	Биет бус хөрөнгө	7,953,800.00	7,953,800.00
39301	Програм хангамж	457,000.00	457,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	7,496,800.00	7,496,800.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>276,487,362.94</u>	<u>372,794,963.99</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>-</u>	<u>3,080,687.62</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	3,080,687.62
413	Өглөг	-	3,080,687.62
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	3,080,687.62
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>276,487,362.94</u>	<u>369,714,276.37</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	276,487,362.94	369,714,276.37
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	59,467,248.00	59,467,248.00
51101	Өмч: - төрийн	59,467,248.00	59,467,248.00
512	Хуримтлагдсан үр дүн	105,614,594.14	198,841,507.57
51210	Өмнөх үеийн үр дүн	105,614,594.14	105,614,594.14
51220	Тайлант үеийн үр дүн	-	93,226,913.43
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	111,405,520.80	111,405,520.80
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>276,487,362.94</u>	<u>372,794,963.99</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	467,720,160.00	684,209,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,975,560.00	28,911,900.00
120	Нийтлэг татварын бус орлого	8,975,560.00	28,911,900.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,975,560.00	28,911,900.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	8,975,560.00	28,911,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	458,744,600.00	655,297,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	458,744,600.00	655,297,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	35,795,400.00	655,297,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	422,523,055.10	590,982,386.57
21	УРСГАЛ ЗАРДАЛ	422,523,055.10	590,982,386.57
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	422,523,055.10	590,581,357.76
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	282,793,485.78	447,802,509.51
210101	Үндсэн цалин	261,374,747.30	378,494,125.17
210102	Нэмэгдэл	17,518,646.36	69,308,384.34
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,377,885.00	21,531,031.00
210201	Тэтгэврийн даатгал	27,532,785.00	18,723,531.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,752,000.00	449,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,359,800.00	393,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	590,000.00	1,291,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,143,300.00	673,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,744,176.99	47,422,671.19
210301	Гэрэл, цахилгаан	2,571,761.99	3,098,494.19
210302	Түлш, халаалт	31,922,415.00	44,204,177.00
210303	Цэвэр, бохир ус	250,000.00	120,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,069,200.00	510,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	975,000.00	510,000.00
2105	Нормативт зардал	40,626,775.00	46,984,290.00
210502	Хоол, хүнс	40,626,775.00	46,984,290.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,971,532.33	26,330,856.06
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,450,689.01	12,389,350.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	3,026,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	9,520,843.32	10,915,406.06
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	401,028.81
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	401,028.81
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	401,028.81
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	45,197,104.90	93,226,913.43
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	45,197,104.90	93,226,913.43

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(Төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	59,467,248	111,405,521	105,614,594	276,487,363
C07	Тайлант үеийн үр дүн	-	-		-
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	59,467,248	111,405,521	105,614,594	276,487,363
D01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	59,467,248	111,405,521	105,614,594	276,487,363
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	59,467,248	111,405,521	105,614,594	276,487,363
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	93,226,913	93,226,913
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	59,467,248	111,405,521	198,841,508	369,714,276

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	458,744,600.00	655,297,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	458,744,600.00	655,297,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	458,744,600.00	655,297,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	35,795,400.00	655,297,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	417,846,036.66	578,251,452.89
21	УРСГАЛ ЗАРДАЛ	417,846,036.66	578,251,452.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	417,846,036.66	577,850,424.08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	282,665,151.66	410,133,632.89
210101	Үндсэн цалин	190,893,434.01	266,317,529.55
210102	Нэмэгдэл	78,183,937.65	139,123,099.95
210104	Урамшуулал	13,490,280.00	4,693,003.39
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,377,885.00	56,806,800.00
210201	Тэтгэврийн даатгал	27,532,785.00	38,628,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,752,000.00	4,544,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,359,800.00	2,272,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	590,000.00	2,272,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,143,300.00	9,089,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,855,400.00	45,517,271.19
210301	Гэрэл, цахилгаан	2,532,985.00	2,948,494.19
210302	Түлш, халаалт	31,922,415.00	41,503,177.00
210303	Цэвэр, бохир ус	400,000.00	1,065,600.00
2105	Нормативт зардал	44,803,100.00	35,724,420.00
210502	Хоол, хүнс	44,803,100.00	35,724,420.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	940,000.00	1,240,000.00
210604	Урсгал засвар	940,000.00	1,240,000.00

Ховд сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	679,700.00	7,140,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	5,335,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	679,700.00	1,804,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,524,800.00	21,288,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,485,800.00	16,227,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,039,000.00	5,060,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	401,028.81
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	401,028.81
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	401,028.81
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	40,898,563.34	77,045,947.11
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	40,898,563.34	77,045,947.11
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		40,898,563.34
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	40,898,563.34	117,944,510.45

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(Төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	696,196,000	577,850,424
21	УРСГАЛ ЗАРДАЛ	696,196,000	577,850,424
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	696,196,000	577,850,424
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	513,004,700	410,133,633
210101	Үндсэн цалин	353,539,900	266,317,530
210102	Нэмэгдэл	152,107,500	139,123,100
210104	Урамшуулал	7,357,300	4,693,003
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59,160,200	56,806,800
210201	Тэтгэврийн даатгал	40,230,200	38,628,600
210202	Тэтгэмжийн даатгал	4,731,600	4,544,600
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,366,400	2,272,300
210204	Ажилгүйдлийн даатгал	2,366,400	2,272,300
210205	Эрүүл мэндийн даатгал	9,465,600	9,089,000
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,918,300	45,517,271
210301	Гэрэл, цахилгаан	3,339,500	2,948,494
210302	Түлш, халаалт	41,513,200	41,503,177
210303	Цэвэр, бохир ус	1,065,600	1,065,600
2104	Хангамж, бараа материалын зардал	-	-
2105	Норматив зардал	44,375,600	35,724,420
210502	Хоол, хүнс	44,375,600	35,724,420
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,240,000	1,240,000
210604	Урсгал засвар	1,240,000	1,240,000

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,445,700	7,140,300
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,641,200	5,335,800
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,804,500	1,804,500
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,051,500	21,288,000
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,898,700	16,227,400
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,152,800	5,060,600
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	655,297,400	654,896,371
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	608,139,100	608,139,100
131001	Улсын төсвөөс санхүүжих	601,497,900	601,497,900
131103	ЗГНХ,ЗДН Хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн	6,641,200	6,641,200
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	47,158,300	46,757,271
132001	Орон нутгийн төсвөөс	47,158,300	46,757,271
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		40,898,563
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		117,944,510

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 734,125.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 720,640.9 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдааг¹ залруулж, баталгаажуулав. Үүнд:

- Санхүүгийн үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайланд санхүүжилтийн орлогыг буруу дансанд бүртгэсэн 655,297.4 мянган төгрөгийг залруулан бүртгүүлсэн.
- Мөнгөн гүйлгээний тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайланд мөнгөн зарлагыг дутуу илэрхийлсэн 65,043.5 мянган төгрөгийг залруулан бүртгүүлсэн.
- Ажилчинд олгосон цалингийн урьдчилгааг суутгаагаагүй 300.0 мянган төгрөгийг цалингийн урьдчилгаа дансанд залруулан бүртгэлээ.

Залруулагдаагүй 13,484.1 зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул “Хязгаарлалтай” дүгнэлт өгсөн

Аудитаар илэрсэн 6 зөрчилд² 1,305.4 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 12.179.4 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өглөө.

3.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт: Тайлант онд аймгийн засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлсэн сүү хөтөлбөрийн зарцуулаагүй үлдэгдлийг төсөвт буцаан төвлөрүүлээгүй 1,305.4 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", 45 дугаар зүйлийн 45.2-д "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

3.2 ЗӨВЛӨМЖ

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.1.1 Хөрөнгийн тооллого

Илрүүлэлт: 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан гарахын өмнө хөрөнгийн тооллогыг хийгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 12 дугаар зүйлийн 12.2.1-т "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайлан гаргахын өмнө хөрөнгийн тооллогыг хийж байх

3.1.2 Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тогтмол зардлын санхүүжилтээс ус цэвэршүүлэх тоног төхөөрөмж худалдан авсан 945.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 41.2.3."төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", 45 дугаар зүйлийн 45.2-д "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийг батлагдсан ангилал, зориулалтын дагуу зарцуулж байх.

3.1.3 Хөрөнгө бүртгэхтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар дотно, гадна камержуулалт хийгдсэн ажлыг бүртгэлд тусгаагүй 5,800.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д "Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккрузл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "жинхэнэ хэрэгжилтийн" 5.1.4-т "үнэн зөв байх", 14 дүгээр зүйлийн 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" "18.1.Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ашиглагдаж байгаа хөрөнгийг шийдвэр гаргуулан бүртгэлд тусгах.

3.1.4 Бараа материалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Хүнсний материалыг зарлага гаргахдаа программд эхний үлдэгдлийг зарлагдаагүй 1,793.1 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эхэлж авснаа эхэлж зарлагдах аргыг ашиглан бүртгэл хөтөлж хэвших

3.1.5 Авлага, өглөгтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн тооцоог тухай бүр бодоогүйгээс өглөг, авлага нэмэгдсэн 3,640.6 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Харилцагч талуудтай тооцоог тухай бүр хийж авлага, өглөг үүсгэхгүй байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1. Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								тоо	Дүн	тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Ховд сумын цэцэрлэг	Санхүүжилтийн орлого дансыг буруу илэрхийлсэн	1	655,297.4			1	655,297.4	1	655,297.4				
	Төсвийн гүйцэтгэлийн болон мөнгөн гүйлгээний тайланд мөнгөн зарлагыг дутуу бүртгэсэн	1	65,043.5	1	65,043.5			1	65,043.5				
	Цалингийн урьдчилгааг суутгааг	1	300.0	1	300.0			1	300.0				
Нийт дүн		3	720,640.9	2	65,343.5	1	655,297.4	3	720,640.9				

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:								
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн		
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
Ховд сумын цэцэрлэг	Сүү хөтөлбөрийн зарцуулаагүй үлдэгдлийг төсөвт төвлөрүүлээгүй	1	1,305.4	1	1,305.4							
	Тогтмол зардлын санхүүжилтээс ус цэвэршүүлэх тоног төхөөрөмж худалдан авсан	1	945.6					1	945.6			
	Жилийн эцсээр хөрөнгийн тооллого хийгээгүй	1	0						1	0		

ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар дотно, гадна камержуулалт хийгдсэн ажлыг бүртгэлд тусгаагүй	1	5,800.0					1	5,800.0		
Хүнсний материалыг зарлага гаргахдаа программд эхний үлдэгдлийг зарлагдаагүй	1	1,793.1					1	1,793.1		
Татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн тооцоог тухай бүр бодоогүйгээс өглөг, авлага нэмэгдсэн	1	3,640.6					1	3,640.6		
Нийт дүн	6	13,484.1	1	1,305.4			5	12,179.4		

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР : Х.БОЛДБААТАР 2025.02.18

АУДИТЫН МЕНЕЖЕР: А.ЦЭЦЭГСҮРЭН 2025.02.18

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР: Н.БАТЖАРГАЛ 2025.02.18